

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2022 оны 07 дугаар сарын 18

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/107 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу байгууллагын 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байгууллагад хамаарах зорилт, арга хэмжээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, шилэн дансны хөтлөлтийг хамруулж үр дүнг үнэллээ.

Нэг. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн талаар

1.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Байгууллага нь хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хүрээнд эхний хагас жилд 18 арга хэмжээний 27 зүйл, заалтыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.1.1. Монгол Улсын хууль 1.а.

Статистикийн тухай /Шинэчилсэн найруулга/ 1, Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 1, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай 3, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай 1 заалт, нийт 4 хуулийн 6 зүйл, заалтын хэрэгжилтийн хувийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зүйл, заалтын тоо	Зүйл, заалтын хэрэгжилтийн хувь				Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Дундаж хувь	Дундаж оноо
			100	70	30	0			
1	11.6.Яам, Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллага чиг үүргийнхээ дагуу статистикийн үйл ажиллагааг эрхэлнэ. Яамд бүтэцдээ салбарын статистикийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэх нэгжтэй байна. 1997.06.05 Статистикийн тухай /Шинэчилсэн найруулга/	1	1	-	-	-	-	100	5.0

2	55.3.Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. 2019.01.01 Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/	1	1	-	-	-	-	100	5.0
3	8.1.2.Монгол Улсад байгаа гадаад улсын иргэн буцах хүсэлт гаргасан тохиолдолд улсын хилээр нэвтрүүлэх талаар холбогдох шийдвэр гаргах; (8.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар Улсын онцгой комисс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:) 9.7.Цар тахлын халдвараар өвчилсөн, өвчилсөн байж болзошгүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Монгол Улсын хилээр оруулахгүй байж болно. 9.14.Хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалтын дэглэм тогтоосны улмаас гадаадын иргэн, харьяалалгүй хүн хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүй, оршин суух зөвшөөрөл аваагүй, визийн болон оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгуулаагүй бол тус нөхцөл байдал арилах хүртэл хугацаанд бүртгэл, хугацаа хэтрүүлсний төлбөр, торгуулиас чөлөөлнө. 2020.04.29 Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай	3	3	-	-	-	-	100	5.0
4	31.1.Энэ хууль хүчин төгөлдөр дагаж мөрдөхөөс өмнө хуулиар зөвшөөрснөөс бусад мэдээлэл хариуцагчийн цуглуулсан биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг устгана. 2022.05.01 Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай	1	1	-	-	-	-	100	5.0
Нийт дундаж хувь								100	5.0

1.1.2. Ерөнхийлөгчийн зарлиг 1.г.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2 зарлигийн 2 зүйл, заалтын хэрэгжилтийн хувийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зүйл, заалтын тоо	Зүйл, заалтын хэрэгжилтийн хувь				Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Дундаж хувь	Дундаж оноо
			100	70	30	0			
1	1.Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус	1	1	-	-	-	-	100	5.0

	үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь: 2. Уул ус, газар нутгаа эрх бүхий байгууллагаас баталсан нэрээр зөв нэрлэж занших, өөрчлөн буруу нэршихээс сэргийлэх, монгол хэлнээс бусад хэлээр орчуулах буюу бусад хэлний дуудлагаар галиглахгүй байхыг Монгол Улсын нийт иргэд, байгууллагад уриалсугай. Нутаг орны газар зүйн нэрийг хамгаалах тухай 2017-07-10 Дугаар 2017_186								
2	3.Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай; Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-05-23 Дугаар 2018_46	1	1	-	-	-	-	100	5.0
Нийт дундаж хувь								100	5.0

1.1.3. Засгийн газрын тогтоол 1.е.

Засгийн газрын 3 тогтоолын 3 заалтын хэрэгжилтийн хувийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зүйл, заалтын тоо	Зүйл, заалтын хэрэгжилтийн хувь					Дундаж хувь	Дундаж оноо
			100	70	30	0	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй		
1	3.Чингэлэгт тээврээр нүүрс экспортлох үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай зөвшөөрлийг яаралтай олгох, холбогдох шийдвэрийг шуурхай гаргаж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Гаалийн ерөнхий газар (Б.Асралт), Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн), Гадаадын иргэн, харьяатын газар (Н.Ууганбаяр), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга), “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ (Б.Гүрсоронзон) болон холбогдох бусад төрийн байгууллагуудад үүрэг болгосугай. 2021_185 Чингэлэгт тээврийн терминал байгуулах тухай /2021-07-02/	1	1	-	-	-	-	100	5.0

2	1.Монгол Улсад 90 хүртэл хоногийн хугацаагаар жуулчлах Бүгд Найрамдах Солонгос Улсын иргэдийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл Монгол Улсын визийн шаардлагаас чөлөөлсүгэй. 2.Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт даалгасугай. 2022_178 Визийн шаардлагаас чөлөөлөх тухай /2022-05-04/	1	1	-	-	-	-	100	5.0
3	5.Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх. 2022_7 Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /2023-01-05/	1	1	-	-	-	-	100	5.0
Нийт дундаж хувь								100	5.0

1.1.4. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 1.ж.

Засгийн газрын 7 удаагийн хуралдаанаас гарсан үүрэг даалгаврын 12 заалтын хэрэгжилтийн хувийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зүйл, заалтын тоо	Зүйл, заалтын хэрэгжилтийн хувь				Хэрэгжилтийг тооцох хугацаа	Дундаж хувь	Дундаж оноо
			100	70	30	0			
1	XIY.2. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх хууль зүй, дотоод хэргийн салбарын үйл ажиллагаатай танилцсан дүнгийн талаар Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар Засгийн	6	6	-	-	-	-	100	5.0

	<p>газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүний эрхийг хангах баталгааг улам бүр сайжруулж, иргэдийн амар амгалан, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, эрх зүйт төрийг хөгжүүлэн төлөвшүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, байгууллагын дарга нарт үүрэг болгов:</p> <p>1.Хууль зүй, дотоод хэргийн салбарын үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт техник, технологи, программ хангамжийг үе шаттайгаар нэвтрүүлэх; 2.салбарын үйл ажиллагаанд цахим засаглалыг хөгжүүлж, холбогдох лавлагаа, тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн үйлчилгээнд цахим үйлчилгээг нэвтрүүлж алба хаагч, ажилтанд ирэх ачааллыг бууруулах; 5.олон нийтэд чиглэсэн хууль тогтоомж, эрх зүйн сургалт сурталчилгааны ажлыг үе шаттайгаар явуулж, гэмт хэрэг, зөрчил үйлдэх, гэмт хэргийн хохирогч болохоос сэргийлэх, иргэд өөрсдөө хуулиа дээдэлж, биелүүлдэг байх чиглэлээр соён гэгээрүүлэх үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулах; 6.албан үүргээ гүйцэтгэсэнтэй холбогдуулан хууль сахиулах байгууллагын алба хаагчдын эрх ашиг, нэр төр хөндөгдсөн тохиолдолд тэднийг хамгаалах, хууль ёсны үйлдлийг иргэдэд тайлбарлан ойлгуулж, буруутай иргэнд хариуцлага тооцож, олон нийтэд мэдээлэх ажлыг сайжруулах; 8.алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, мэргэшүүлэх, нийгмийн баталгааг хангах, ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах чиглэлээр сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлсэн арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хамрах хүрээг нэмэгдүүлж ажиллах; 9.алба хаагчдын ёс зүй, сахилга, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, иргэдтэй зөв боловсон, соёлтой, харьцах, ажил, үйлчилгээний шуурхай байдлыг хангахад тогтмол анхаарч, алба хаагч бүр авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлж ажиллах.</p> <p>2020_59 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр 59 дүгээр тэмдэглэл 2020-11-11</p>								
2	<p>Ү.Төрийн цахим шилжилтийн бодлогын уялдааг хангах, төрийн байгууллагуудын мэдээллийн санг нэгтгэн зохион байгуулах замаар төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шуурхай, чирэгдэлгүй, оновчтой хүргэх арга хэмжээ авахыг</p>	1	1	-	-	-	-	100	5.0

	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нарт даалгав. 2020_69 2020 оны 12 дугаар сарын 9-ны өдөр 69 дугаар тэмдэглэл 2020-12-09								
3	ХҮ.9.2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний эрх шилжүүлэх болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулах асуудлыг ирэх оны төсөв батлагдсан даруйд шийдвэрлүүлж, холбогдох байгууллагад хүргүүлэх, худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг зарлаж 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор зохион байгуулж дууссан байхаар тооцож, бэлтгэл хангахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгав; ХҮ.9.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний эрх шилжүүлэх болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулах асуудлыг ирэх оны төсөв батлагдсан даруйд шийдвэрлүүлж, холбогдох байгууллагад хүргүүлэх, худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг зарлаж 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор зохион байгуулж дууссан байхаар тооцож, бэлтгэл хангахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгав; 2021_55 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 55 дугаар тэмдэглэл 2021-10-13	1	1	-	-	-	-	100	5.0
4	ХИХ.6.2.“Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав. 2022_11 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2022-02-16	1	1	-	-	-	-	100	5.0
5	ХҮИИ.17.2.Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн шуурхай зохион байгуулж, тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг худалдан авах ажиллагааны цахим	1	1	-	-	-	-	100	5.0

	системд оруулж, ажиллахыг Төсвийн шууд захирагч нарт даалгав; 2022_16 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дугаар тэмдэглэл 2022-03-16								
6	ХҮ.2.5.Бүгд Найрамдах Солонгос Улсын аялагчдыг визийн шаардлагаас чөлөөлөх, хил орчмын жуулчдын автомашинтай аяллыг дэмжих арга хэмжээг зохих журмын дагуу авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ нарт. 2022_20 2022 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр 20 дугаар тэмдэглэл 2022-04-06	1	1	-	-	-	-	100	5.0
7	XI.2. Биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, спортын холбоодын тэргүүн, сонгуульт албан тушаалтны ажлыг хавсран гүйцэтгэхгүй байх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яам, агентлаг, төрийн өмчит компани болон үйлдвэрийн газрын удирдлага, захирлуудад даалгав. 2022_22 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр 22 дугаар тэмдэглэл 2022-04-13	1	1	-	-	-	-	100	5.0
Нийт дундаж хувь								100	5.0

1.2.Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Тус байгууллагаас хэрэгжүүлж байгаа 2 зорилтын хүрээнд 4 арга хэмжээний хэрэгжилтийн хувийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Заалтын тоо	Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн хувь					Дундаж хувь	Дундаж оноо	
			100	90	70	30	0			Үнэлэх боломжгүй
1	4.3.9. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно. 1.Хөшигийн хөндийн шинэ нисэх буудалд агаарын тээврээр зорчигчийн урьдчилсан мэдээллийг хүлээн авах дэвшилтэд систем /APP/-ийг нэвтрүүлэх, зорчигчийн урьдчилсан мэдээллийг хүлээн авч боловсруулалт хийх, хариу мэдээлэх мэдээллийн төвийг байгуулна. 2.Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.	3	1	1	-	-	-	1	95	4.75

	3.Хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газарт Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөллийг бий болгож, виз, визийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэн, Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудыг уг мэдээллийн сантай холбоно.									
2	4.5.1.Аялал жуулчлал, хөрөнгө оруулалтыг дэмжих ажлын хүрээнд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Монгол Улсын виз олгох журмыг шинэчлэн батлуулах зэргээр хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. Монгол Улсын виз олгох үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан цахим визийн систем нэвтрүүлэх, мөн виз мэдүүлгийн төвийг хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан байгуулах зэрэг шинэлэг арга хэлбэрийг бий болгоно.	1	1	-	-	-	-	-	100	5.0
Нийт дундаж хувь									97.5	4.87

Үнэлгээнд оруулан тооцох боломжгүй дараах заалтыг хяналтаас хасуулах саналтай байна:

Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, Хөшигийн хөндийн шинэ нисэх буудалд агаарын тээврээр зорчигчийн урьдчилсан мэдээллийг хүлээн авах дэвшилтэд систем /APP/-ийг нэвтрүүлэх, зорчигчийн урьдчилсан мэдээллийг хүлээн авч боловсруулалт хийх, хариу мэдээлэх мэдээллийн төвийг байгуулна. (Хэрэгжих хугацаа 2020-2024)

Үндэслэл: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд уг зорилтод тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд Гадаадын иргэн, харьяатын газрын оролцоог тусгаагүй бөгөөд үндсэн хэрэгжүүлэгч байгууллага нь Хууль зүй, дотоод хэргийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар, хамтрагч байгууллага нь Боомтын үндэсний зөвлөл, оролцогч байгууллага нь Иргэний нисэхийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар байхаар заасан.

Байгууллагын бодлогын баримт бичгийн 2022 оны эхний хагас жилийн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 100 хувь буюу 5.0 оноотой, үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 хувиар, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 97.5 хувь буюу 4.87 оноотой байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Ерөнхий үнэлгээ 98.7 хувь буюу 4.93 оноотой байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.2 хувиар өсчээ. Хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт		Үнэлгээ				Харьцуулалт /хувиар/
		2021 оны эхний хагас жил		2022 оны эхний хагас жил		
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	99	4.95	100	5.0	+1
	1.1. Монгол Улсын хууль	100	5.0	100	5.0	-
	1.2. Ерөнхийлөгчийн зарлиг	100	5.0	100	5.0	-
	1.3. Засгийн газрын тогтоол	100	5.0	100	5.0	-
	1.4. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	94	4.7	100	5.0	+6
	2. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	70	3.5	97.5	4.87	+27.5
Ерөнхий үнэлгээ		84.5	4.22	98.7	4.93	+14.2

Эхний хагас жилийн байдлаар бодлогын баримт бичгийн дараах арга хэмжээнүүдийн хэрэгжилт үр дүнтэй байлаа. Үүнд:

1. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Дэлхийд ганц босоо зурлагатай монгол бичгээ хамтдаа сурцгаая” аяны хүрээнд Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 02 дугаар сарын 28-ны өдөр батлан, хэрэгжилтийг ханган, “Монгол бичиг”-ийн сорилд 51 албан хаагчийг хамруулан мэдлэгийн түвшингээр эрэмбэлж, байгууллагын даргын 03 дугаар сарын 25-ны өдөр баталсан “Сургалт зохион байгуулах тухай” 01-03/17 дугаар удирдамжын дагуу Монгол Улсын зөвлөх багш Б.Оюунаа 04 дүгээр сарын 05-аас 28-ны өдрийн хооронд “Монгол бичиг”-ийн анхан, дунд шатны танхимын сургалтыг зохион байгуулж, нийт 36 албан хаагчийг хамруулсан.

Агаарын замын боомт хариуцсан газар 04, 05 дугаар сард, Баруун бүс дэх газар 05 дугаар сард “Монгол бичгийн хичээл”-ийг тус бүр зохион байгуулсан бол Зүүн бүс дэх газар 01 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн албан хаагчдыг 7 хоног тутам, Дорноговь аймаг дахь газар 04 дүгээр сарын 11-ээс 05 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл 3 дахь жилдээ “Монгол бичгийн хичээл”-ийг зохион байгуулж албан хаагчдаа хамруулжээ.

“Монгол бичиг-III” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Үндэсний бичиг, үсгийн баяр”-ыг тохиолдуулан Дорноговь аймаг дахь газрын 19 албан хаагч “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-ийг Монгол бичигт хөрвүүлснийг байгууллагын цахим хуудаст нээлттэй байршуулж, олон нийтэд сурталчиллаа.

Баруун бүс дэх газар албан өрөөнүүдийн хаягийг Үндэсний бичигт хөрвүүлэн шинэчилж, нийт компьютерт монгол бичгийн үсгийн программ суулгав. Мөн Зүүн бүс дэх газар архив-бичиг хэргийн эрхлэгчийн ажлын компьютерт монгол бичгийн үсгийн программ суулгасан байна.

Байгууллагын гаднах хаяг, туг, байгууллагад ашиглаж байгаа 1 тамга, 1 тэмдэг, боомт, орон нутаг дахь нэгж тус бүрийн албаны байрны гаднах хаяг, нийт 7 тэмдэг, албан хаагчдын ялгах тэмдэг (жетон, ханцуй, малгайн бэлгэ, тэмдэг)-т үндэсний бичгийг оролцуулсан бичиглэлтэй байна. Мөн байгууллагын 2022 оны цаг тооны хуанли дахь бичвэрийг кирилл, монгол бичгээр хослуулан бичиж, хэвлүүлсэн.

2. Хууль зүй, дотоод хэргийн салбарын үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт техник, технологи, программ хангамжийг үе шаттайгаар нэвтрүүлэх ажлын хүрээнд гадаадын иргэнд дахин давтагдахгүй бүртгэлийн дугаар буюу F-

Register олгох системийг хөгжүүлж 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн.

Гадаадын иргэнийг 48 цагийн дотор бүртгүүлэх ухаалаг утасны программ хангамжийг хөгжүүлж, 2021 оны 10 дугаар сараас iOS, Android үйлдлийн системд нэвтрүүлэв.

Байгууллагын цахим хуудас (immigration.gov.mn)-ыг шинэчлэн, НҮБ-ын 5 хэл дээр хөгжүүллээ.

Визийн мэдээллийн нэгдсэн сан (evisa.mn) системийг 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаанд нэвтрүүлж, тайлант хугацаанд нийт 34 улсын 2983 иргэнд цахим виз олгожээ. eimmigration.mn цахим хуудсыг 2021 оны 10 дугаар сар, 2022 оны 03, 05 дугаар саруудад үе шаттайгаар хөгжүүлж, визийн зөвшөөрөл, оршин суух хугацааны сунгалт, түүний хасалтын хүсэлтийг цахимаар гаргах үйлчилгээг нэвтрүүллээ.

3.Олон нийтэд чиглэсэн хууль тогтоомж, эрх зүйн сургалт сурталчилгааны чиглэлээр соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах ажлын хүрээнд эхний хагас жилийн байдлаар байгууллагын цахим хуудаст үйл ажиллагаатай холбоотой 65 мэдээ, мэдээллийг байршуулж, давхардсан тоогоор 245 хэвлэл мэдээллийн хэрэгсэл (телевизээр 18, сонинд 13, сайтад 214)-д нийтлүүлсэн.

“Шинэ сэргэлтийн бодлого ба эрх зүйн орчны танилцуулга” сэдвээр 03 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан уулзалт, зөвлөгөөний үйл ажиллагааг Монголын мэдээ суваг, Ийгл телевиз, NTV телевизээр сурталчилж, gogo.mn, ikon.mn, zindaa.mn, zarig.mn, ontslokh.mn, selem.mn, mnb.mn, ivoice.mn, updown.mn, 24tsag.mn, said.mn зэрэг 20 орчим сайтад мэдээллийг нийтлүүлэв.

Үйл ажиллагааны мэдээллийг англи хэлээр Монголын Үндэсний олон нийтийн телевизийн MNB World сувгаар 03 дугаар сарын 14-ний өдөр нэвтрүүллээ. Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран 05 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулсан “Гадаадын ажиллах хүч, цахим виз, хөрөнгө оруулалт, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар санал солилцох нь” сэдэвт уулзалтыг NTV, TV9, MN25, МҮОНТ зэрэг 11 телевиз, 2 сонин, 8 сайтаар олон нийтэд сурталчилсан.

Evisa.mn цахим системийн ажиллагаа, үйлчилгээний дарааллыг товч, ойлгомжтой байдлаар танилцуулсан 2 минут 42 секундийн видео шторкийг англи, монгол хэлээр нийт 4 сайтад нийтлүүлэв. Гадаадын иргэн, харьяатын газрын Үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг илэрхийлсэн 3 минут 15 секундийн видео шторкийг 04 дүгээр сарын 06-ны өдрийн 01/658 дугаар албан бичгээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлж ажиллалаа.

Хоёр. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ

2.1. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам” болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 8 дугаар хавсралтын дагуу байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулан, 01 дүгээр сарын 05-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулсан.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 стратеги зорилго, 8 зорилтын хүрээнд 67 арга хэмжээ төлөвлөснөөс эхний хагас жилд хэрэгжүүлэх 8 зорилтын 62 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

№	Зорилт	Арга хэмжээ	Гүйцэтгэлийн үнэлгээ							Дундаж хувь
			100 %	90 %	80 %	70 %	50 %	10 %	0 %	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Зорилт 1. Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлэх (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний гуравдугаар зорилт)	9	2	3		2	1		1	73.3
2	Зорилт 2. Гадаадын иргэн, харьяатын эрх зүйн шинэтгэлийг нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн эрчимжүүлэх (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний нэгдүгээр зорилт)	1	1							100.0
3	Зорилт 3. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үр дүнтэй механизмыг нэвтрүүлнэ. /ХЗДХС-ын ЭАХ-ний 2021-2024 ҮАСТ-ний 7.4/	12	11	1						99.2
4	Зорилт 4. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах	11	9			1			1	88.2
5	Зорилт 5. Байгууллагын үйл ажиллагааг оновчтой төлөвлөн, тайлагнах, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах	13	12					1		93.1
6	Зорилт 6. Гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх, гадаадын ижил чиг үүргийн байгууллагын хөгжлийн дэвшлийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний зорилт 4)	4	1	2	1					90.0
7	Зорилт 7. Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах	5	3	2						96.0
8	Зорилт 8. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, ажиллах нөхцөл, бололцоог дээшлүүлэн, дэмжин ажиллана.	7	2	1		2	1		1	68.6
Нийт		62	41	9	1	5	2	1	3	88.6

Нийт арга хэмжээний 41 буюу 66 хувь нь үр дүнтэй, 15 буюу 24 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн, 2 буюу 3 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 4 буюу 7 хувь нь үр дүнгүй байна.

Зорилт тус бүрээр ангилан үзвэл “Гадаадын иргэн, харьяатын эрх зүйн шинэтгэлийг нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн эрчимжүүлэх”, “Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үр дүнтэй механизмыг нэвтрүүлэх” зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ хамгийн үр дүнтэй буюу 100 хувь, 99.2 хувиар, “Албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, ажиллах нөхцөл, бололцоог дээшлүүлэн, дэмжин ажиллах” зорилтод тусгагдсан ажлууд хамгийн бага буюу 68.6 хувиар тус тус үнэлэгдсэн.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилт 88.6 хувьтай үнэлэгдсэн нь өмнөх оны мөн үетэй (81.7 хувь) харьцуулахад 6.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Гурав. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ

3.1. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд улирал бүр дотоод аудит хийн, нэгжүүдэд хэрэгжилтийг эрчимжүүлэх, өмнөх зөрчлийг давтан гаргахгүй байх, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зөвлөмж хүргүүлж, шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг www.shilendans.gov.mn, www.immigration.gov.mn цахим хуудаст байршуулж ажилласан.

Тайлант хугацаанд нийт 600 мэдээлэл байршуулахаас 598 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, 99.7 хувь буюу “хангалттай” үнэлэгдсэн байна.

№	Байгууллагын нэр	2022 оны эхний хагас жилийн байдлаар						
		Нийт байршуулах мэдээлэл	Байршуулсан мэдээлэл	Хугацаандаа байршуулсан	Хугацаа хоцроон байршуулсан мэдээлэл	Байршуулаагүй мэдээлэл	Хугацаа болоогүй	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	Гадаадын иргэн, харьяатын газар	75	75	75	-	-	-	100.0
2	Агаарын замын боомт хариуцсан газар	75	75	73	2	-	-	97.25
3	Дорноговь аймаг дахь газар	75	75	75	-	-	-	100.0
4	Хойд бүс дэх газар	75	75	75	-	-	-	100.0
5	Өмнөд бүс дэх газар	75	75	75	-	-	-	100.0
6	Баруун бүс дэх газар	75	75	75	-	-	-	100.0
7	Зүүн бүс дэх газар	75	75	75	-	-	-	100.0
8	Баян-Өлгий аймаг дахь хэлтэс	75	75	75	-	-	-	100.0
Бүгд дүн		600	600	598	2	-	-	99.7

Дүгнэлт

Гадаадын иргэн, харьяатын газрын 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн 95.7 хувь буюу 4.78 оноотой үнэлэгдлээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.8 хувь буюу 0.39 оноогоор өссөн үзүүлэлттэй байна. Үүнд:

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт 14.2 хувиар, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 6.9 хувиар, шилэн дансны хөтлөлийн биелэлт 2.3 хувиар тус тус өссөн.

Мэдээллийн технологийн дэвшлийг төрийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх зорилтын хүрээнд тайлант хугацаанд цахим систем, программ хангамж хөгжүүлэх томоохон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажилласан ба цаашид виз, бүртгэлийн цахим үйлчилгээ, программ хангамжийн хөгжүүлэлтүүдийг эрчимжүүлэн, системийг чанаржуулж, илүү боловсронгуй болгоход анхааран ажиллаж байна.

Цаашид үр дүнтэй хэрэгжсэн, тодорхой үр дүнд хүрсэн арга хэмжээний эхний хагас жилийн үр дүнг бууруулахгүй, жилийн эцэст зорилт, арга хэмжээний биелэлтийг бүрэн хангаж, үнэлгээг ахиулж ажиллах, бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, төсөв, хөрөнгөөс шалтгаалан явц удаашралтай, үр дүнд хүрээгүй ажлуудыг эрчимжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг сайжруулах шаардлагатай.

Журмын 6 дугаар хавсралт

Үзүүлэлт		Үнэлгээ				Харьцуулалт /хувиар/
		2021 оны эхний хагас жил		2022 оны эхний хагас жил		
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	99.0	4.95	100.0	5.0	+1
	2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	70.0	3.5	97.5	4.87	+27.5
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	81.7	4.08	88.6	4.43	+6.9
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1.Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	97.4	4.87	99.7	4.98	+2.3
Ерөнхий үнэлгээ		87.9	4.39	95.7	4.78	+7.8

--oo0oo--